

ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН 2008 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА

2008 оны 2 дугаар улирлын байдлаар Хорооноос даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, даатгалын зуучлагч 4 компани болон даатгалын төлөөлөгч 818 иргэн даатгалын зах зээлд оролцсон байна.

I. ХӨРӨНГӨ

Энэ оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй дээрх 20 компанийн хөрөнгийн нийт хэмжээ 34.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.4 тэрбум төгрөг буюу 42.4 хувиар өссөн байна. Нийт хөрөнгийн хэмжээний энэхүү өндөр өсөлт нь урт хугацааны амьдралын даатгалын үйл ажиллагаа эрхлэхээр “Нэйшнл лайф даатгал” компани даатгалын зах зээлд шинээр орж ирсэнтэй холбоотой.

2007 оны 2 дугаар улиралд системийн дүнгээр нийт эргэлтийн хөрөнгө 21.2 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 86.5 хувь, эргэлтийн бус хөрөнгө 3.3 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 13.5 хувийг эзэлж байсан бол 2008 оны 2 дугаар улиралд эргэлтийн хөрөнгө 30.5 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 87.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 0.9 пунктээр өссөн нь тайлант хугацаанд хөрөнгийн бүтцэд онцын өөрчлөлт гараагүйг харуулж байна (Хүснэгт-1).

Хүснэгт-1
(сая төг)

Үзүүлэлтүүд	2007-II		2008-II		өсөлт/бууралт	
	Тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Эргэлтийн хөрөнгө	21 241.2	86.6	30 497.2	87.4	9 256.0	143.6
Эргэлтийн бус хөрөнгө	3 277.0	13.4	4 433.7	12.6	1 156.7	135.3
Нийт хөрөнгө	24 518.2	100.0	34 930.9	100.0	10 412.7	142.5

2008 оны 2 дугаар улирлын байдлаар эргэлтийн хөрөнгийн 60.5 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 20.8 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 6.6 хувийг дансны авлага, үлдэх 12.1 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өнгөрсөн оны 2 дугаар улиралтай харьцуулахад богино хугацаат хөрөнгө оруулалтын хэмжээ 4.9 дахин, түүний эзлэх хувь хэмжээ нь 14.7 пунктээр өсч хөрөнгийн бүтцэд нилээд өөрчлөлт гарсан нь өнгөрөгч 2007 оны 2 дугаар улиралд “Номин даатгал”, “Миг даатгал” ХХК-иуд богино хугацаат хөрөнгө оруулалт хийж байсан бол энэ оны 2 дугаар улиралд “Ган зам даатгал”, “Жонон даатгал”, “Прайм женерал даатгал”, “Миг даатгал”, “Монгол даатгал”, “Номин даатгал”, “Нэйшнл лайф даатгал” ХХК-иуд богино хугацаат хөрөнгө оруулалт хийсэнтэй холбоотой байна (Хүснэгт-2).

Хүснэгт-2
(сая төг)

Үзүүлэлтүүд	2007-II		2008-II		өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	16 126.8	75.9	18 459.9	60.5	2 333.1	114.5
Богино хугацаат хөрөнгө	1 301.5	6.1	6 331.2	20.8	5 029.7	4.9

оруулалт						
Дансны авлага	2 488.7	11.7	2 007.4	6.6	-481.3	дахин 80.7
Бусад эргэлтийн хөрөнгө	1 324.2	6.2	3 698.7	12.1	2 374.5	2.8 дахин
Эргэлтийн хөрөнгийн дүн	21 241.2	100.0	30 497.2	100.0	9 256.0	143.6

Энэ оны эхний хагас жилийн байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 13.0 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр нийт даатгалын зах зээл дээрх хөрөнгийн 37.3 хувийг дангаараа эзэлж байсан бол “Нийслэл даатгал” ХХК хамгийн бага буюу 0.7 тэрбум төгрөгийн хөрөнгөөр зах зээлийн нийт хөрөнгийн 1.9 хувийг эзэлж байна (Хүснэгт-3).

Даатгалын зах зээл дээрх нийт хөрөнгийн 50 гаруй хувийг ердөө 3 даатгалын компани (“Монгол даатгал”, “Бодь даатгал”, “Миг даатгал”) –ийн хөрөнгө бүрдүүлж байна.


Хүснэгт-3

№	Компанийн нэр	Нийт хөрөнгө (сая төг)	Эзлэх хувь
1	Монгол даатгал	13 014.5	37.3
2	Бодь даатгал	3 310.9	9.5
3	Миг даатгал	2 211.5	6.3
4	Прайм женерал даатгал	2 019.5	5.8
5	Ард даатгал	1 874.7	5.4
6	Номин даатгал	1 786.5	5.1
7	Түшиг даатгал	1 509.7	4.3
8	Практикал даатгал	1 484.7	4.3
9	Нэйшнл лайф даатгал	1 296.5	3.7
10	Улаанбаатар хотын даатгал	1 284.0	3.7
11	УБ даатгал	1 042.1	3.0
12	Монгол траст Холдинг даатгал	924.3	2.6
13	Ган зам даатгал	865.0	2.5
14	Жонон даатгал	841.7	2.4
15	Мөнх даатгал	804.6	2.3
16	Нийслэл даатгал	660.7	1.9
	САЛБАРЫН НИЙТ ДҮН	34 930.9	100.0

II. ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

2008 оны 2 дугаар улиралд өр төлбөр 24.6 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 70.5 хувь, нөөцийн сангийн нийт өр төлбөрт эзлэх хувь 91.9 болсон нь өмнөх оны мөн үеийнхээс нийт өр төлбөр 43.8 хувиар, энэ оны жилийн эхнээс 24.9 хувиар өссөн байна (Зураг-1).

Зураг-1



Энэ оны эхний хагас жилд даатгалын зах зээл дэх даатгалын нөөцийн сангийн хэмжээ 22.6 тэрбум төгрөгт хүрч 2007 оны эхний хагас жилтэй харьцуулахад 48.7 хувиар буюу 7.4 тэрбум төгрөгөөр, 2008 оны эхтэй харьцуулахад 27.0 хувиар буюу 4.8 тэрбум төгрөгөөр өслөө.

Тайлант хугацаанд даатгалын салбарын хэмжээгээр 372.9 сая төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай ажилласан бол өнгөрсөн онд 1.0 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан байна.

III. ОРЛОГО, ЗАРДАЛ

Тайлант хугацаанд даатгалын салбар 14.4 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсноос 3.3 тэрбум төгрөг буюу 22.9 хувийг давхар даатгалын хураамжид, 0.04 тэрбум төгрөг буюу 0.3 хувийг буцаасан даатгалын хураамжид олгож 11.0 тэрбум төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлого олжээ.

Орлогод тооцсон хураамжийн 15.1 хувийг учирч болзошгүй хохирлын нөөц сан бүрдүүлэхэд, 30.1 хувийг нөхөн төлбөр олгоход зориулсан байна.

2007 оны эхний хагас жилд даатгалын салбар 71.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол энэ оны эхний хагас жилд 370.0 сая төгрөгийн ашиг (татвар төлөхийн өмнөх)-тай ажилласан нь даатгалын зах зээл дээрх үйл ажиллагаа нилээд идэвхжиж байгааг харуулж байна.


Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа 16 даатгалын компанийг 2008 оны 2 дугаар улиралд олсон даатгалын хураамжийн орлогоор нь жагсаахад “Монгол даатгал” ХХК 4.4 тэрбум төгрөг буюу нийт зах зээлийн 31.0 хувийг эзэлж хамгийн өндөр орлого олсон бол “Нэйшнл лайф даатгал” ХХК 18.4 мянган төгрөгийн хураамжийн орлого олсон байна (Хүснэгт-4). Даатгалын зах зээл дэх нийт хураамжийн орлогын 55.8 хувийг “Монгол даатгал”, “Бодь даатгал” ХХК-иудын олсон хураамжийн орлого бүрдүүлж байна.

Хүснэгт-4
(сая.төг)

№	Компанийн нэр	Хураамжийн орлого	Эзлэх хувь
1	Монгол даатгал	4 448.2	31.0
2	Бодь даатгал	3 559.4	24.8
3	Миг даатгал	1 390.3	9.7
4	Практикал даатгал	875.5	6.1
5	Прайм женерал даатгал	765.5	5.3
6	Номин даатгал	730.7	5.1
7	Мөнх даатгал	659.6	4.6
8	Түшиг даатгал	556.2	3.9
9	Ард даатгал	511.3	3.6
10	Улаанбаатар хотын даатгал	333.0	2.3
11	Жонон даатгал	229.5	1.6
12	Нийслэл даатгал	90.6	0.6
13	УБ даатгал	86.9	0.6
14	Ган зам даатгал	76.6	0.5
15	Монгол траст холдинг даатгал	48.1	0.3
16	Нэйшнл лайф даатгал	0.0	0.0
	НИЙТ ДҮН	14 361.4	100.0

IV. ДААТГАЛЫН ХУРААМЖ, НӨХӨН ОЛГОВОР

2008 оны 2 дугаар улиралд нийт 14.3 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсны 61.1 хувь буюу 8.7 тэрбум төгрөг нь эд хөрөнгийн даатгалын, 26.5 хувь буюу 3.8 тэрбум төгрөг нь хариуцлагын даатгалын, 9.8 хувь буюу 1.4 тэрбум төгрөг нь амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгалын, 2.6 хувь буюу 0.4 тэрбум төгрөг нь санхүүгийн даатгалын хураамжаас орсон орлого байна (Зураг-2). Санхүүгийн даатгалын хэлбэр бий болж зах зээлд нэвтэрснээр энэ хэлбэрийн даатгалын хураамжийн орлого нийт хураамжийн орлогод багаахан хувь эзэлдэг болсныг эс тооцвол тайлант хугацаанд хураамжийн орлогын бүтцэд дорвитой өөрчлөлт гарсангүй.



2008 оны 2 дугаар улирлын даатгалын хураамжийн орлогын хэмжээг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад даатгалын нийт хураамжийн орлого 4.3 тэрбум төгрөгөөр буюу 42.6 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтийг даатгалын ангилалаар нь задлан харвал амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал 77.1 хувиар буюу 0.6 тэрбум төгрөгөөр, эд хөрөнгийн даатгал 41.8 хувиар буюу 2.6 тэрбум төгрөгөөр, хариуцлагын даатгал 24.1 хувиар буюу 0.7 тэрбум төгрөгөөр, санхүүгийн даатгалын хураамж 19.1 дахин буюу 0.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна (Хүснэгт-5).

Хүснэгт-5


(сая төг)

Даатгалын ангилал	2007-II		2008-II		Өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал	790.2	7.9	1 399.3	9.8	609.1	177.1
Эд хөрөнгийн даатгал	6 155.6	61.5	8 726.7	61.1	2 571.1	141.8
Хариуцлагын даатгал	3 047.6	30.4	3 782.6	26.5	735.0	124.1
Санхүүгийн даатгал	19.4	0.2	370.8	2.6	351.4	19.1 дахин
Дүн	10 012.7	100.0	14 279.4	100.0	4 266.7	142.6

Энэ оны эхний хагас жилд 2.4 тэрбум төгрөгийн нөхөн олговор олгосны 73.7 хувь буюу 1.8 тэрбум төгрөг нь эд хөрөнгийн даатгалын, 15.7 хувь буюу 0.4 тэрбум төгрөг нь хариуцлагын даатгалын, 7.7 хувь буюу 0.2 тэрбум төгрөг нь амь нас, ашиг сонирхол, эрүүл

мэндийн даатгалын, 3.0 хувь буюу 0.1 тэрбум төгрөг нь санхүүгийн даатгалын нөхөн төлбөр байна (Зураг-3).

(Зураг-3)



Энэ оны эхний хасаг жилд олгосон нөхөн олговрын хэмжээг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад нийт нөхөн олговрын хэмжээ 61.0 хувиар буюу 0.9 тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтийг даатгалын ангилалаар нь авч үзвэл амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгалын нөхөн олговор 23.6 хувиар буюу 57.1 сая төгрөгөөр буурсан бол эд хөрөнгийн даатгал 69.3 хувиар буюу 0.7 тэрбум төгрөгөөр, хариуцлагын даатгал 83.1 хувиар буюу 0.2 тэрбум төгрөгөөр, санхүүгийн даатгал 240 дахин буюу 71.7 сая төгрөгөөр тус тус өссөн байна (Хүснэгт-6).

Хүснэгт-6
(сая төг)

Даатгалын ангилал	2007-II		2008-II		Өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал	242.4	16.1	185.3	7.7	-57.1	76.4
Эд хөрөнгийн даатгал	1 052.4	70.1	1 781.7	73.7	729.3	169.3
Хариуцлагын даатгал	207.0	13.8	379.1	15.7	172.1	183.1
Санхүүгийн даатгал	0.3		72.0	3.0	71.7	240 дахин
Дүн	1 501.8	100	2 418.1	100	916.3	161.0

V. НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН

2008 оны 2 дугаар улирлын байдлаар хохирол нөхөлтийн түвшин даатгалын салбарын дүнгээр 16.9 хувь болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 1.9 пунктээр өссөн байна. Хохирол нөхөлтийн түвшинг даатгалын ангилалаар авч үзвэл амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал 13.2 хувь болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 17.5 пунктээр буурсан бол эд хөрөнгийн даатгал 20.4 хувь болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.3 пунктээр, хариуцлагын даатгал 10.0 хувь болж 3.2 пунктээр, санхүүгийн даатгал 19.4 хувьд хүрч 17.9 пунктээр тус тус өссөн байна (Хүснэгт-7).

Хүснэгт-7
(сая төг)

Даатгалын ангилал	2007-II			2008-II		
	Хураамжийн орлого	Нөхөн олговор	Нөхөн олговрын түвшин	Хураамжийн орлого	Нөхөн олговор	Нөхөн олговрын түвшин
Амь нас, ашиг сонирхол, эрүүл мэндийн даатгал	790.2	242.4	30.7%	1 399.3	185.3	13.2%
Эд хөрөнгийн даатгал	6 155.6	1 052.4	17.1%	8 726.8	1 781.7	20.4%
Хариуцлагын даатгал	3 047.6	207.0	6.8%	3 782.6	379.1	10.0%
Санхүүгийн даатгал	19.4	0.3	1.5%	370.8	72.0	19.4%
Дүн	10 012.7	1 501.8	15.0%	14 279.4	2 418.1	16.9%

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудын нөхөн олговрын түвшинг харахад 2008 оны 2 дугаар улирлын байдлаар “Мөнх даатгал” ХХК-ийн нөхөн олговрын түвшин 75.5 хувьд хүрч хамгийн өндөр байгаа бол “Бодь даатгал” ХХК 4.5 хувьтайгаар хамгийн бага түвшинд байна. (Хүснэгт-8).

Хүснэгт-8
(сая төг)

№	Даатгалын компанийн нэрс	2007-II			2008-II		
		Хураамжийн орлого	Нөхөн олговор	Нөхөн олговрын түвшин	Хураамжийн орлого	Нөхөн олговор	Нөхөн олговрын түвшин
1	Ард даатгал	461.1	74.3	16.1%	511.3	105.8	20.7%
2	Бодь даатгал	3 317.3	100.7	3.0%	3 550.3	159.7	4.5%
3	Ган зам даатгал				76.6	5.3	6.9%
4	Жонон даатгал	203.1	8.4	4.1%	32.5	10.6	32.6%
5	Прайм женерал даатгал	596.1	72.7	12.2%	765.5	87.6	11.4%
6	Практикал даатгал	213.1	29.4	13.8%	875.5	51.9	5.9%
7	Миг даатгал	667.6	178.0	26.7%	1 390.3	99.6	7.2%
8	Монгол даатгал	3 054.0	856.3	28.0%	4 448.2	1019.2	22.9%
9	Монголтраст холдинг даатгал	66.8	1.5	2.2%	48.1	15.6	32.4%

10	Мөнх даатгал	104.3	61.1	58.6%	551.5	416.2	75.5%
11	Нийслэл даатгал	85.2	4.3	5.0%	90.6	14.1	15.6%
12	Номин даатгал	582.2	59.3	10.2%	962.9	279.1	29.0%
13	Түшиг даатгал	299.2	29.6	9.9%	556.2	84.8	15.2%
14	УБ даатгал	92.2	10.9	11.8%	86.9	14.4	16.6%
15	Улаанбаатар хотын даатгал	270.6	15.4	5.7%	333.0	54.3	16.3%
ДҮН		10 012.7	1 501.8	15.0%	14 279.4	2 418.1	16.9%

VI. ДАВХАР ДААТГАЛ

Энэ оны эхний хагас жилд даатгалын 7 компани давхар даатгуулж 3.7 тэрбум төгрөгийн хураамж төлсөн нь өнгөрөгч оны эхний хагас жилтэй харьцуулахад 0.2 тэрбум төгрөг буюу 5.1 хувиар өссөн байна.

2008 оны 2 дугаар улиралд төлсөн нийт давхар даатгалын хураамжийн 73.6 хувийг Бодь даатгал ганцаараа бүрдүүлж байна (Хүснэгт-9).

Хүснэгт-9
(сая төг)

№	Компанийн нэр	2007-II		2008-II	
		Хураамжийн орлого	Эзлэх хувь	Хураамжийн орлого	Эзлэх хувь
1	Ард даатгал	86.5	2.5	11.7	0.3
2	Бодь даатгал	2 718.3	78.0	2 696.9	73.6
3	Миг даатгал	162.1	4.6	369.4	10.1
4	Монгол даатгал	415.1	11.9	464.7	12.7
5	Мөнх даатгал	104.3	3.0	-	-
6	Прайм женерал даатгал	-	-	89.9	2.5
7	Практикал даатгал	-	-	9.1	0.2
8	Номин даатгал	-	-	21.4	0.6
ДҮН		3 486.3	100.0	3 663.1	100.0

VII. ДҮГНЭЛТ

2008 оны эхний хагас жилийн даатгалын салбарын тоон үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад ерөнхийдөө даатгалын салбар нилээд өргөжин тэлж байгаа дүр зураг ажиглагдаж байна. Тухайлбал салбарын гол үзүүлэлт болох нийт хөрөнгийн хэмжээ 42.5 хувь буюу 10.4 тэрбум төгрөгөөр, хуримтлагдсан нийт ашиг өнгөрөгч оны мөн үед 1.0 тэрбумын алдагдалтай байсан бол 372.9 сая төгрөг болж алдагдал 2.7 дахин буурсан, тайлант хугацааны ашиг өнгөрөгч онд 71.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол энэ онд 370.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Даатгалын бизнесийн гол орлого болох даатгалын хураамжийн орлого ч мөн адил тайлант хугацаанд нилээд өндөр өсөлттэй буюу 42.6 хувьтай байсан бол нөхөн төлбөр 61.0 хувиар буюу 0.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

